



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Загвар хуудас батлах тухай

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолоор баталсан “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-ын 1.3, 4.1.3 дах заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үүрэг хүлээсэн хэрэглэгчээс бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрчим хүчний хэрэглээний мэдээллийг авах асуулгын загвар хуудсыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Батлагдсан загвар хуудасны дагуу үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс мэдээллийг авах, мэдээлэл авах хуудсыг бөглөх үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэгээр ханган, хамтран ажиллахыг Эрчим хүч хэмнэлтийн газар /Ц.Атаржаргал/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



А.ТЛЕЙХАН

Д.БАССАЙХАН

Э.ТҮВШИНЧУЛУУН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн
50 дугаар тогтоолын хавсралт

**ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧДЭЭС ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХЭРЭГЛЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ АСУУЛГЫН ХУУДАС**

Мэдээллийн нууцыг Монгол Улсын "Байгууллагын нууцын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 2 дугаар заалт, "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу тус тус нууцлан хадгална.

ХЭСЭГ I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Байгууллагын мэдээлэл

| | |
|--|-------------------------------|
| Байгууллагын нэр: | Хаяг: |
| Барилгын нэр: | Байгууллагын шуудангийн хаяг: |
| Барилга эзэмшдэг, ашиглалт хариуцдаг байгууллагын нэр: | Хаяг: |
| Хуулийн этгээдийн хэлбэр: <input type="checkbox"/> ХК <input type="checkbox"/> ХХК <input type="checkbox"/> ББН <input type="checkbox"/> ЗБН <input type="checkbox"/> ХХН <input type="checkbox"/> Хоршоо <input type="checkbox"/> ТББ <input type="checkbox"/> ТӨААТҮГ <input type="checkbox"/> ОНӨААТҮГ <input type="checkbox"/> ТБАГУТҮГ <input type="checkbox"/> Бусад | |
| Өмчийн хэлбэр: <input type="checkbox"/> Төрийн өмчит <input type="checkbox"/> Төрийн өмчийн оролцоотой <input type="checkbox"/> Орон нутгийн өмчит <input type="checkbox"/> Орон нутгийн өмчийн оролцоотой <input type="checkbox"/> Хувийн хэвшлийн <input type="checkbox"/> Гадаадын иргэн, компанитай хамтарсан <input type="checkbox"/> 100% гадаадын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Бусад | |
| Байгууллагын удирдах албан тушаалтны нэр, албан тушаалын нэр: | Гар утас: |
| Ажлын утас/факс: | Цахим шуудангийн хаяг: |
| Эрчим хүч хэмнэлтийн менежерийн нэр: | Гар утас: |
| Ажлын утас/факс: | Цахим шуудангийн хаяг: |
| Ажил үйлчилгээний чиглэл: | Байгуулагдсан огноо: |
| Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилал: <input type="checkbox"/> Дулааны ЭХ-ний хэрэглээ <input type="checkbox"/> Цахилгааны ЭХ-ний хэрэглээ <input type="checkbox"/> Дотоод хэрэгцээ <input type="checkbox"/> Дамжуулалтын алдагдал <input type="checkbox"/> Түгээлтийн алдагдал | |

2. Ажил үйлчилгээний хүчин чадал

| Жил | Ажил үйлчилгээний төрөл | Хэмжих нэгж | Суурилагдсан хүчин чадал | Бодит ашиглалт | Хүчин чадлын ашиглалтын % |
|------|-------------------------|-------------|--------------------------|----------------|---------------------------|
| 2014 | | | | | |
| 2015 | | | | | |
| 2016 | | | | | |

| | |
|---|----------------------|
| Хоногийн ажлын цаг: | Жилийн ажлын өдрүүд: |
| Ээлжийн тоо : <input type="checkbox"/> 1 ээлж <input type="checkbox"/> 2 ээлж <input type="checkbox"/> 3 ээлж | |